

2017 оны 1 дүгээр сарын 31

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын  
санаачилга – Монгол Улс

ЕСБХБ- Орон нутаг  
дахь мэдээлэл  
харилцааны  
туршилтын хөтөлбөр

**Эхлэлийн тайлан**



# Товчилсон үгс

---

АСИ	Адам Смит Интернейшнл
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ОУ	Олборлох үйлдвэрлэл
МОУИТБС	Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ОТООХ	Олон талт оролцогчдын ажлын хэсэг

# Агуулга

---

1.	Танилцуулга	1
2.	ЕСБХБ-ны Орон нутгийн мэдээлэл харилцааны хөтөлбөрийн зорилт болон гол бүтээгдэхүүн	1
3.	Эхлэл хугацаанд хамаарах үйл ажиллагаа	2
4.	Эхлэл хугацаан дахь гол үр дүнгүүд болон ажиглагдсан зүйлс	3
5.	Ажлын төлөвлөгөө	3
6.	Боловсон хүчин	10
7.	Олон талт оролцогчдын ажлын хэсгийн үүрэг роль	10

# Эхлэлийн тайлан

---

## 1. Танилцуулга

Энэхүү баримт бичиг нь Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр, Адам Смит Интернейшнл байгууллагын хэрэгжүүлж буй Монголын ОУИТБС-ын Орон нутгийн мэдээлэл харилцааны хөтөлбөрийн (Хөтөлбөр) Эхлэлийн тайлан болно. Тайланд доорх зүйлсийг тусгасан:

- Хөтөлбөрийн **зорилт**;
- **Эхлэлийн хугацаанд** авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, голлох үр дүнгүүд;
- Хөтөлбөрийн **ажлын төлөвлөгөө**, үүнд мөн цаашид хийж гүйцэтгэх үүрэг даалгавар болон гарах бүтээгдэхүүнүүдийг тусгасан; мөн
- Хөтөлбөрийн **баг**.

2012 онд ЕСБХБ-ны зүгээс АСИ-д хандан Монгол Улс дахь ОУИТБС-ын хэрэгжилтэд үндэсний хэмжээнд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүргийг ноогдуулсан билээ. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд ОУИТБС-ын хуулийн төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх, Монголын ОУИТБС-ын мэдээлэл харилцааны стратегийг бэлтгэхэд туслах, сургалтын арга хэмжээг зохион байгуулах, “Цахим тайлангийн систем” болон онлайн мэдээллийн портал үүсгэх зэрэг үүргүүд багтаж байжээ. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөнд өртөж буй олон нийтэд ОУИТБС-ыг таниулах, тэдний хоорондын хамаарлыг сайжруулах, уул уурхайн салбарыг хэрхэн зөв удирдах асуудлаарх хэлэлцүүлэгт олон нийтийг мэдээллээр хангахад нэмэр болох зорилгоор ЕСБХБ нь Монголын ОУИТБС-ын Ажлын албатай хамтран шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх шийдэлд хүрсэн юм. Ашигт малтмалын орлого хуваалцах тогтолцоо ихээхэн чухал үүрэгтэй Монгол зэрэг зарим орнуудад ОУИТБС-ыг ашиглах, орон нутаг тэр тусмаа **сумдын** түвшинд хэлэлцүүлгийн индэр байдлаар ашиглах нь оролцогч талуудад олон боломжуудыг нээн өгч буйн жишээнд:

- Олборлох үйлдвэрлэлийн компаниудад өөрсдийн үйл ажиллагааны талаар орон нутгийн иргэдэд тайлбарлан ойлгуулах, орон нутгийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр, орон нутаг болон улсын төсөвт төвлөрүүлж буй орлогынхоо хэмжээг мэдээллэх;
- Засгийн газрын хувьд олон нийтийн хэрэгцээ, тэдэнд тулгараад буй асуудлуудыг сайтар ойлгон, олборлох салбарын үйл ажиллагааг зохицуулах, удирдах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар олон нийттэй илүү үр дүнтэй харилцах боломж үүсэх; болон
- Иргэний нийгмийн байгууллагуудад орон нутагтай хамааралтай мэдээллийн хүртээмж сайжирч, үүний үр дүнд олборлох салбарын компаниуд болон төрийн байгууллагуудаас хариуцлага шаардах боломж нээгдэнэ.

Энэхүү хөтөлбөр нь **туршилтын хөтөлбөр** болохыг цохон дурдах нь зүйтэй. Хөтөлбөр нь шинэ санаа, санаачилгууд, хандлагыг хязгаарлагдмал хэмжээнд (5 хүртэлх тооны сумдад) турших, эдгээр туршилтаас тодорхой сургамжууд авсаны үндсэн дээр, хөтөлбөрийг цаашид өргөн хүрээнд амжилттай хэрэгжүүлэх боломжтой юм. Ингэснээр хөтөлбөрийн үйл ажиллагаанд чухал нөлөөлөл үзүүлэх бөгөөд туршилтын хугацаанд шинэ мэдлэг олох бүрт хөтөлбөрийн удирдлагын чиг хандлагыг үйл ажиллагаа, нөөц эх үүсвэрийн хувьд уян хатнаар хэрэгжүүлж, ямар нэгэн өөрчлөлтгүйгээр тогтсон хөтөлбөрийн зорилтуудыг хангахад чиглүүлэх боломжтой болох юм. Дээрх шалтгааны улмаас энэхүү Эхлэл хугацааны тайланд багтсан ажлын төлөвлөгөөг хөтөлбөрийн хугацаанд өөрчилж болох бөгөөд ЕСБХБ болон Монголын ОУИТБС-ын Ажлын албанд тухайн хийгдсэн өөрчлөлтүүдийн талаар тайлагнаж байх болно.

## 2. ЕСБХБ-ны Орон нутгийн мэдээлэл харилцааны хөтөлбөрийн зорилт болон гол бүтээгдэхүүн

Олон нийтийн хэлэлцүүлгийг мэдээллээр хангах болон олборлох салбарын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх хэмээх ОУИТБС-ын гол үндэслэл нь доор дурдагдсан **хөтөлбөрийн зорилттой** шууд уялдаа холбоотой билээ:

- Ашигт малтмалын салбарын удирдлагын хөгжлийн талаар орон нутгийн иргэд, оролцогч талуудын мэдлэгийг нэмэгдүүлэх замаар ил тод байдлыг хангах **Монголын ОУИТБС-ын чадавхийг сайжруулах**.

Дээр дурдсан зорилтыг хангахын тулд хөтөлбөр нь доор дурдсан хэд хэдэн гол **бүтээгдэхүүнийг** гаргахад чиглэн ажиллах болно:

- Хөтөлбөрийн зүгээс үйл ажиллагаа явуулах 5 сумыг сонгон авахад ашигласан шалгуур үзүүлэлт болон үйл явцын талаарх **Сум сонголтын тайлан**;
- Орон нутаг дахь оролцогч талуудтай зөвлөлдөх, тэдэнд хамаарах асуудлууд, тэргүүлэх хэрэгцээг тодорхойлох, мэдээлэл харилцааны хамгийн зохистой хэлбэрийг тогтоох зорилгоор ОТОАХ-ын зарим гишүүдийн хамтаар **зорилтот 5 суманд ажиллах**;
- Монголын ОУИТБС-ын одоо хэрэгжүүлж буй Мэдээлэл харилцааны стратегийг судлан үнэлж** одоогийн байдлаар Ажлын алба болон бусад оролцогч талуудын зүгээс орон нутагт төвлөрөн ажиллаж буй байдал, мэдээлэл харилцааны үйл ажиллагааг судлан үнэлэх;
- Цаашид орон нутагт хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагаанд Монголын ОУИТБС-ын зүгээс баримтлан ажиллахад зориулсан **Орон нутгийн мэдээлэл харилцааны ерөнхий стратеги** бэлтгэн гаргах;
- Үйл ажиллагаа явуулах эхний зорилтот суманд хэрэгжүүлэх **мэдээлэл харилцааны төлөвлөгөөг** бэлтгэх, **мэдээлэл түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх**;
- Үлдэх 4 суманд хэрэгжүүлэх **мэдээлэл харилцааны төлөвлөгөөг** бэлтгэх, **мэдээлэл түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх**; болон
- Ирээдүйд Монголын ОУИТБС-ын зүгээс, боломжтой тохиолдолд ЕСБХБ-ны дэмжлэгтэйгээр, мэдээлэл түгээх үйл ажиллагааг хэрхэн бусад сумдад түгээн хэрэгжүүлэх талаар дурдсан **Түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны тайлан**.

### 3. Эхлэл хугацаанд хамаарах үйл ажиллагаа

Хөтөлбөрийн нь 2016 оны 11 дүгээр сарын 28-ний өдрөөс эхэлсэн ч 12 дугаар сарын 12-ний өдрөөс 2017 оны 1 дүгээр сарын 16-ны хооронд түр завсарласан болно. Хөтөлбөрийн эхлэл хугацаа нь 2017 оны 2 дугаар сарын 3-ний өдөр албан ёсоор дуусгавар болно. Эхлэл хугацаанд бидний зүгээс доор дурдсан үйл ажиллагааг хийж гүйцэтгэлээ:

- Хөтөлбөрийн зохицуулагч ажилд авсан ба Н.Золжаргал энэхүү албан тушаалд ажиллахаар сонгогдон АСИ-тэй албан ёсны гэрээг хийсэн. Хөтөлбөрийн зохицуулагч нь ОУИТБС-ын Ажлын албан дээр байрлан үйл ажиллагаа явуулна;
- Хөтөлбөрийн зохицуулагч Монголын ОУИТБС-ын орон нутгийн сургалт-семинарт оролцсон;
- ЕСБХБ-ны талаас төслийн удирдагч П.Моффат болон АСИ-ийн ажилтнууд Улаанбаатар хотод ажилласан;
- Монголын ОУИТБС-ын Ажлын алба болон бусад талуудтай уулзалтууд хийсэн;
- Хөтөлбөрийн ажлын төлөвлөгөөг эцэслэн гаргасан;
- Монголын ОУИТБС болон АСИ-тэй Монголын талаас хамтран ажиллах мэдээлэл харилцааны чиглэлийн компанийг сонгох асуудал болон Ажлын төлөвлөгөөнд заагдсан тодорхой ажил үүргүүдийн талаар хэлэлцүүлэг хийсэн;
- Хамгийн олон уншигч бүхий “Өдрийн сонин” дээр мэдээлэл харилцааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани сонгон ажиллуулах тухай зарыг түгээн, саналаа ирүүлэхийн хүсэмжилсэн;
- Мэдээлэл харилцааны олон улсын зөвлөх Сефтон Дербиг ажиллуулахаар болсон бөгөөд Зөвлөх нь сумдын хэрэгцээний үнэлгээний үйл ажиллагааг удирдахын зэрэгцээ, Монголын ОУИТБС-ын хэрэгжүүлж буй Мэдээлэл харилцааны стратеги, орон нутгийн түвшинд өмнө хийгдсэн үйл ажиллагааг судлан үнэлэлт дүгнэлт өгнө;
- Хөтөлбөрийн хүрээнд ямар сумдад үйл ажиллагаа явуулахыг шийдэхэд ашиглах шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан;
- Боломжит мэдээлэл цуглуулсан; болон
- Энэхүү Эхлэлийн тайланг бэлтгэн гаргасан.

## 4. Эхлэл хугацаан дахь гол үр дүнгүүд болон ажиглагдсан зүйлс

Дэлхийн банкны үзэж буйгаар Монгол Улсын хөдөө орон нутагт тулгарч буй гол асуудал нь байгалийн баялагийн үр шимийн хүртээмжийн тэгш бус байдал, байгаль орчны доройтол болон орон нутгийн иргэдийн ажлын байрны хомсдол зэрэгтэй нягт холбоотой байна. Уул уурхай, байгаль орчны салбарт үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын тоо өнгөрсөн арван жилийн хугацаанд хурдтай өссөн нь хөдөө орон нутагт хариуцлага, эргэн тайлагналыг сайжруулах эрэлт хэрэгцээ өндөр буйг харуулж байна. Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь орон нутгийн түвшинд эдгээр иргэний нийгмийн байгууллагуудтай, жишээ нь “Төлсөн авсанаа нийтэл” эвсэлтэй нягт хамтран ажиллаж, ашигт малтмалын орлогын урсгалын талаарх мэдээлэл цуглуулах, тухайн орлогоос дутагдаж буй алдагдал, авлигжсан үйл явц зэргийг тодорхойлоход хамтран ажиллаж байна. Сумдын хэрэгцээний үнэлгээ хийх болон хөтөлбөрийн хэрэгжилтийн бусад үе шатуудад бид эдгээр иргэний нийгмийн байгууллагуудтай зөвлөлдөх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Дээр дурдагдсан үйл ажиллагаануудаас гадна эхлэлийн хугацаанд сумдын түвшин дэхь олборлох үйлдвэрлэл болон нийгэм-эдийн засгийн анхдагч мэдээллийн хүртээмж, чанарын талаарх анхдагч судалгаа хийж гүйцэтгэх үйл ажиллагаа мөн багтаж байна. Үндэсний статистикын газартай хийсэн уулзалтын үр дүнд орон нутаг дахь ажилгүйдлын хувь хэмжээ, удирдах түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүдийн хувь хэмжээ зэрэг тоон мэдээллийг гаргах боломжгүй эсвэл эдгээр мэдээ нь орон нутгаар бус харин үндэсний хэмжээнд л буй болох нь тогтоогдсон. Ийнхүү сумын түвшин мэдээлэл хомс буй нь хөтөлбөрт хамрагдах сумдыг сонгон шалгаруулахад ашиглах шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах үйл явцад сөргөөр нөлөөлж болно.

Эхлэлийн шатны бусад гол үр дүнгүүдэд доорх мөн багтаж байна:

- Мэдээлэл харилцааны чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компанийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг түргэн эхлүүлсэнээр тухайн компани нь орон нутагт хийгдэх сумдын үнэлгээнд оролцох боломжтой болно. Ингэснээр мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа болон үйл ажиллагааны хэрэгжилтийн хооронд мэдлэг дамжуулах үйл явцыг үр дүнтэй явуулахад дэмжлэг болох юм. Хараат бус хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсад бүртгэлтэй компани нь хөтөлбөрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай ур чадварыг ханган өгөхийн зэрэгцээ, Монгол дахь ОУИТБС-тай шууд хамааралтай компани сонгогдон ашиг сонирхлын зөрчилдөөн үүсэхээс зайлсхийхэд тустай болох юм.
- Монголын ОУИТБС-ын Ажлын алба болон Мэдээлэл харилцааны олон улсын зөвлөхийн өмнөх туршлагад тулгуурлан сумдад ажиллахдаа “фокус бүлгийн” хандлагыг ашиглан Сумдын хэрэгцээний үнэлгээг хийх ба энэ нь оролцогч талуудад өөрсдийн санал бодол, санаа зовниж буй асуудлаа чөлөөтэй хуваалцах боломжийг олгох юм.

## 5. Ажлын төлөвлөгөө

Тус хөтөлбөр нь 2016 оны 12 дугаар сараас 2017 оны 12 дугаар сарыг хүртэл нэг жилийн хугацаанд хэрэгжинэ. Тайлангийн энэхүү хэсэгт хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд гүйцэтгэх үндсэн үүргүүд болон бүтээгдэхүүнүүдийн (гарц) талаар тайлбарласан болно. Доорх *Хүснэгт 1* нь хөтөлбөрийн иж бүрэн ажлын төлөвлөгөөг, долоо хоног бүрээр Ганттын хүснэгт харуулсан.

### 5.1 Эхлэл шат

Эхлэлийн шатанд бидний зүгээс авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тайлангийн 3 дугаар хэсэг дээрээс үзнэ үү.

### 5.2 Сумдын анхдагч жагсаалт гаргах, туршилтаар хөтөлбөр хэрэгжүүлэх сумдыг сонгох

Эхлэл хугацаа дуусгавар болсоны дараа хөтөлбөрийн баг нь мэдээлэл түгээх үйл ажиллагааг туршилтын хэлбэрээр хэрэгжүүлэх сумдыг сонгох шалгуур үзүүлэлтийг эцэслэн боловсруулна. Монголын ОУИТБС-ын Ажлын албатай хамтран бид “нарийвчлан шүүх” хандлагыг ашиглан, хөтөлбөрийн зүгээс үйл ажиллагаагаа явуулах боломжтой Монгол Улс дахь бүхий л сумдыг юуны өмнө судлан үзэж,



улмаар эдгээрийн дундаас 10 сумыг сонгон авч дахин судлан үзсэний үндсэн дээр 5 сумыг судлан, нэгийг нь сонгох ба энэхүү үйл явцыг диаграмм дээр харууллаа. 2 дугаар сарын дунд үе гэхэд сум сонгох үйл явцыг дуусгасны дараа **Сум сонголтын тайланг** бэлтгэн гаргаж, энэхүү тайланд 5 сумыг сонгоход ашигласан шалгуур үзүүлэлт, үндэслэлийг тайлбарлан оруулах юм. Тухайн тайланг ЕСБХБ, Монголын ОУИТБС-ын Ажлын алба болон ОТОАХ-т хүргүүлэх ба улмаар ОТОАХ-ийн хурлыг зохион байгуулан тухайн асуудлаар гишүүдийн санал, бодлыг сонсох саналыг бидний зүгээс гаргаж байна. Энэхүү хуралдааныг 2017 оны 2 дугаар сарын 20 болон 3 дугаар сарын 3-ны өдрүүдэд зохион байгуулах нь тохиромжтой бөгөөд Цагаан сарын хугацаа энэ үеэр тохиож буйг мөн харгалзан үзнэ.

### 5.3 Сумдын хэрэгцээний үнэлгээ

**Сумдын хэрэгцээний үнэлгээг** хийхдээ тухайн сонгон авсан 5 сум бүрт 2017 оны 3 дугаар сарын 16-31-ний өдрийн хооронд нийт 14 хоногийн хугацаанд үнэлгээний баг очиж ажиллана. Энэхүү үнэлгээний ажлыг Олон улсын мэдээлэл харилцааны мэргэжилтэн Сефтон Дерби удирдан, Хөтөлбөрийн зохицуулагч болон Монголын ОУИТБС-ын ажилтнууд дэмжлэг үзүүлнэ. Бидний зүгээс ОТОАХ дэхь оролцогч талуудын бүлгийг төлөөлөх нэг нэг гишүүн (Засгийн газар, компани болон иргэний нийгмийг төлөөлөх нийт 3 гишүүн) энэхүү Сумдын хэрэгцээний үнэлгээнд оролцохыг санал болгож байна. Тухайн үнэлгээнд оролцох гишүүдийн зардлыг Монголын ОУИТБС-ын журмын дагуу гаргах болно. Түүнчлэн ЕСБХБ-ны төлөөлөл Пол Моффат зарим сумдад ажиллах үед мөн оролцох болно. Дээр дурдсанчлан, эхлэл шатанд олж тогтоосноор Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй мэдээлэл харилцааны компани мөн энэхүү үнэлгээнд оролцвол үр дүнтэй байх болно.

Сумдын хэрэгцээний үнэлгээний зорилго нь доорх зүйлсэд төвлөрнө:

- Компани, төр, иргэний нийгэм болон хэвлэл мэдээллийг төлөөлөх ОУИТБС-ын орон нутгийн хамаарах оролцогч талуудыг тодорхойлох;
- Тухайн суманд тохирох, хамгийн зохистой мэдээлэл харилцааны хэлбэрийг тогтоох, жишээ нь иргэдийн нийтийн уулзалт, сонин, радио гэх мэт;
- ОУИТБС-ын талаарх ойлголт, мэдээллийг үнэлэх;
- Сумын түвшинд уул уурхайн салбартай хамгийн их хамааралтай асуудлуудыг олж тогтоох;
- Мэдээллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх орон нутгийн талуудын, ялангуяа иргэний нийгмийн чадавхийг тогтоох; болон
- Өмнө хийгдсэн мэдээлэл түгээх бусад үйл ажиллагааг судлан үзэх;
- Өөрийн мэдээлэл түгээх үйл ажиллагаанд ашиглаж болох цаашид хийгдэх олон нийтийн арга хэмжээг олж тодорхойлох; мөн
- Олон нийтэд нэр хүнд бүхий хүмүүс болон манлайлах түвшний хүмүүс мэдээлэл түгээх үйл ажиллагаанд оролцох боломжтой эсэхийг тодорхойлох.


Эхлэл хугацаанд хийгдсэн зөвлөлдөх үйл ажиллагаанд үндэслэн хөтөлбөрийн багийн зүгээс дээр дурдсан мэдээллийг цуглуулах хамгийн зохистой арга зам нь доор харуулсанчлан фокус бүлгийн аргачлал байхыг тодорхойлон гаргасан. Үнэлгээний үеэр сумын ЗДТГ-ын байр, хурлын байр зэргийг ашиглах бөгөөд өдөрт 2 удаа буюу өглөө болон үдээс хойш хоёр удаагийн фокус бүлгийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Оролцогч талуудын бүлгийн төлөөллийн тэгш оролцоог хангахын тулд хөтөлбөрийн баг нь оролцогчдыг урин оролцуулах олон төрөл арга замыг ашиглах ба үүнд:

- Багийн дарга нар арга хэмжээний талаар сурталчлах, ЗДТГ-ын байрны орчимд зурагт хуудас байршуулах;
- Өмнө тогтоосон хэлхээ холбоогоо ашиглан ОУИТБС-ын Ажлын алба суманд үйл ажиллагаа явуулж буй компаниудын төлөөллийг урин оролцуулах;
- Сэтгүүлчдийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр аймгийн түвшинд ажилласан Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын сүлжээг ашиглах; болон
- ОУИТБС-ын Ажлын албатай холбоотой орон нутгийн ИНБ, ТББ-уудтай хамтран ажиллаж, тэднийг хамруулах.

Судалгаанд цөөн хүн бүхий бүлгүүдийг хамруулахын зорилго нь талууд чөлөөтэй байж, өөрсдийн санал бодлыг илэрхийлэх боломжийг олгох явдал юм. Фокус бүлгийн ярилцлагаас гадна ганцаарчлан зөвлөлдөх, ярилцлага хийх, бага хэмжээний санал асуулгын хуудсыг цөөн тооны өрхүүд, орон нутгийн дэлгүүр, төрийн албан хаагч нар, эмнэлэг болон сургуулийн ажилтнуудад тараан бөглүүлэх замаар нэмэлт мэдээлэл цуглуулах боломжтой. Санал асуулгын хуудсыг Хөтөлбөрийн зохицуулагч болон Хөтөлбөрийн менежер ОУИТБС-ын Ажлын алба, Мэдээлэл



харилцааны олон улсын зөвлөхийн оролцоотойгоор сумдад ажиллахын өмнө буюу 2 дугаар сард багтаан боловсруулна. Үнэлгээний үр дүнг **Сумдын хэрэгцээний үнэлгээний тайланд** дэлгэрэнгүй оруулан, тайланг 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр гарган өгнө.



#### 5.4 Мэдээлэл харилцааны стратеги, хамаарах үйл ажиллагаа судлан үнэлэх

Монголын ОУИТБС-ын одоо хэрэгжүүлж буй мэдээлэл харилцааны стратегийг судлан үнэлж, орон нутаг төвлөрч буй үйл ажиллагааны цар хүрээ, үр дүнг тодорхойлох үйл ажиллагааг Мэдээлэл харилцааны олон улсын зөвлөх Сефтон Дерби болон АСИ-ийн Мэдээлэл харилцааны зөвлөх Жулиа Бакстериин дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэнэ. Энэхүү үйл ажиллагааг Сумдын хэрэгцээний үнэлгээтэй зэрэг хийх ба үүний хүрээнд сумд дахь оролцогч талуудтай фокус бүлэг, асуумж, уулзалтууд зохион байгуулан, үнэлгээнд шаардлагатай мэдээллийг цуглуулна. Сефтон Дерби нь мөн Монголын ОУИТБС-ын зүгээс хэрэгжүүлж ирсэн орон нутаг дахь үйл ажиллагааг судлан, тогтоох ба ихэнх өмнөх үйл ажиллагаа нь сумдын бус харин аймгийн түвшинд явагдсан болохыг анхаарч ажиллана. Мөн Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (GiZ) болон бусад хөгжлийн түншлэгч байгууллагууд орон нутагт үйл ажиллагаа явуулсанаас авсан сургамжийг олж тогтоох ажлыг гүйцэтгэнэ. Энэхүү ажил үүргээс гарах бүтээгдэхүүн нь 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр эцэслэгдэн гарах **Мэдээлэл харилцааны үйл ажиллагааны үнэлгээний тайлан** байх юм.

#### 5.5 Орон нутаг дахь мэдээлэл харилцааны ерөнхий стратеги

**Орон нутаг дахь мэдээлэл харилцааны чиглэлээр баримтлах ерөнхий стратегийг** АСИ-ийн Мэдээлэл харилцааны зөвлөх Жулиа Бакстериин тусламжтайгаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй мэдээлэл харилцааны чиглэлийн компани боловсруулан гаргана. Монголын ОУИТБС-ын зүгээс мэдээлэл харилцааны чиглэлээр орон нутагт хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагааны чиглэлийг гаргах Ерөнхий стратеги нь үзэл баримтлалын хувьд сум нэг бүрийн онцлог хэрэгцээнд нийцэхүйц уян хатан байх болно. Стратегийг 2017 оны 5 дугаар сарын 5-ны өдөр эцэслэн дуусгаж, ОТОАХ-ийн гишүүдэд хүргүүлнэ. Үүний дараагаар **ОТОАХ-ийн хурлаар** тухайн ерөнхий стратегийн талаар санал авч, хэрэгжилт болон үүнд гарч буй ахицын талаар гишүүдэд байнга мэдээлэл хүргэж байна.

#### 5.6 Мэдээлэл харилцааны үйл ажиллагааны хэрэгжилтийн төлөвлөгөө (Сум 1)

Үндсэн ерөнхий стратеги боловсруулах үйл ажиллагааг эцэслэснээр бид **Мэдээлэл харилцааны үйл ажиллагааны хэрэгжилтийн төлөвлөгөөг** эхний сонгогдсон суманд зориулан боловсруулах үйл ажиллагааг эхлүүлнэ. Одоогоор төлөвлөж байгаачлан энэхүү үйл ажиллагааг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй мэдээлэл харилцааны компани, Хөтөлбөрийн зохицуулагч болон Монголын ОУИТБС-ын Мэдээлэл харилцааны менежер тэргүүлэн ажиллана. Төлөвлөгөөг 2017 оны 3 дугаар сарын 12-нд эцэслэн дуусгах бөгөөд үүнд доорх зүйлс багтсан байна:

- Хүлээгдэж буй үр дүнгүүд;
- Хийгдэх онцлог үйл ажиллагаа болон хамаарах хугацаа;
- Үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүргийг хэн хүлээх, үүнд шаардлагатай бол орон нутгийн хувь хүмүүс, байгууллагуудыг ашиглах;
- Сумын иргэдээс хэнийг урьж үйл ажиллагаанд хамруулах;

- Үйл ажиллагааг хэн хариуцан мониторинг хийж, хэрэгжүүлсэн арга хэмжээг дэлгэрэнгүй баримтжуулах (жишээ нь зураг, видео болон тайлбар гэх мэт);
- Цахим тайлагналын мэдээллийн порталыг хэрхэн ашиглах тухай; болон
- Дэлгэрэнгүй төсөв.

### **5.7 Мэдээлэл түгээх туршилтын хөтөлбөрийн хэрэгжилт (Сум 1)**

Мэдээлэл түгээх туршилтын хөтөлбөрийн хэрэгжилт нь хамаарах Төлөвлөгөө батлагдсаны дараа шууд эхлэнэ. Одоогоор үүний хүрээнд ямар үйл ажиллагаа явуулахыг тодорхойлох боломжгүй бөгөөд учир нь тухайн үйл ажиллагааг эхний зорилтот сумын нөхцөл байдалд нийцсэн Ерөнхий стратегийн хүрээнд тодорхойлон гаргах юм. Дээр дурдсанчлан тухайн хөтөлбөрийн удирдлагыг уян хатан байдлаар явуулах хэрэгцээг бидний зүгээс сайтар ойлгож буй бөгөөд үйл ажиллагаа явуулах хугацаанд олж авсан мэдлэгийг тусган, үйл ажиллагааг өөрчлөн явуулж байх шаардлагатай билээ. Тиймээс энэхүү эхлэлийн шатанд сонгогдох сум бүр дээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа бүрийг тайлбарлан энд дурдах нь сөрөг нөлөөтэй байх юм. Туршилтаар хэрэгжүүлэх мэдээлэл түгээх хөтөлбөр хэрэгжиж дуусахад Хөтөлбөрийн зохицуулагч нь Сум 1-д хамаарах **Туршилтын хэрэгжилтийн тайланг** бэлтгэн гаргах ба тус тайлан нь үйл ажиллагаанаас гарсан гол амжилтууд (эсвэл алдаа), авсан гол сургамжуудыг үнэлсэн байна. Энэхүү тайланг ОТОАХ-ийн гишүүдэд тарааж, тухайн авсан сургамжуудын талаар **ОТОАХ-ын хурлыг** зохион байгуулж, цаашдын үйл ажиллагаанд шаардлагатай саналыг авах болно.

### **5.8 Туршилтын хөтөлбөрийг сонгон авсан сумдад өргөтгөн хэрэгжүүлэх**

Туршилтын үеийн хэрэгжилтийн тайлан болон ОТОАХ-ийн хуралдаанаас гарах санал зэргийг тусган **Түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөөг** гаргах ба үүнд тухайн хөтөлбөрийг бусад сумдад хэрхэн түгээн хэрэгжүүлэх талаар тусгасан байна. Энэ шатанд бидний зүгээс хэрэгжүүлэх төлөвлөгөөг бэлтгэн, үлдэх дөрвөн сумдад ээлж ээлжээр мэдээлэл түгээх үйл ажиллагааг явуулсанаар нэг сумаас авсан сургамжуудыг дараагийн сумдад түгээн дэлгэрүүлэхээр төлөвлөж байна. Гэхдээ хөтөлбөрийн хэрэгжилт нь өөр өөр нөхцөл бүхий орон нутгуудад явагдахыг бид мөн анхааран үзэх болно.

### **5.9 Мэдээлэл харилцааны үйл ажиллагааны хэрэгжилтийн төлөвлөгөө (Сум 2)**

Энэхүү үйл ажиллагаа нь дээрх 5.7 дугаар хэсэгт дурдагдсан Сум 1 дээр хэрэгжүүлэхтэй ижил үйл явцын дагуу хийгдэнэ.

### **5.10 Мэдээлэл түгээх туршилтын хөтөлбөрийн хэрэгжилт (Сум 2)**

Энэхүү үйл ажиллагаа нь дээрх 5.8 дугаар хэсэгт дурдагдсан Сум 1 дээр хэрэгжүүлэхтэй ижил үйл явцын дагуу хийгдэнэ.

Сум 2 болон 3 дээрх үйл ажиллагааны хэрэгжилтын дунд үед Үндэсний их баяр наадмын хугацаа давхцах тул хөтөлбөрийн үйл ажиллагааны түвшинг тухайн хугацаанд багасгах ба энэхүү хугацаа ойролцоогоор нэг сар орчим үргэлжлэнэ. Олон тооны орон нутгийн оролцогч талууд энэ хугацаанд хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцох боломжгүй тул дээрх шийдвэрийг гаргасан болно.

### **5.11 Мэдээлэл харилцааны үйл ажиллагааны хэрэгжилтийн төлөвлөгөө (Сум 3)**

Энэхүү үйл ажиллагаа нь дээрх 5.7 дугаар хэсэгт дурдагдсан Сум 1 дээр хэрэгжүүлэхтэй ижил үйл явцын дагуу хийгдэнэ.

### **5.12 Мэдээлэл түгээх туршилтын хөтөлбөрийн хэрэгжилт (Сум 3)**

Энэхүү үйл ажиллагаа нь дээрх 5.8 дугаар хэсэгт дурдагдсан Сум 1 дээр хэрэгжүүлэхтэй ижил үйл явцын дагуу хийгдэнэ.

### **5.13 Мэдээлэл харилцааны үйл ажиллагааны хэрэгжилтийн төлөвлөгөө (Сум 4)**

Энэхүү үйл ажиллагаа нь дээрх 5.7 дугаар хэсэгт дурдагдсан Сум 1 дээр хэрэгжүүлэхтэй ижил үйл явцын дагуу хийгдэнэ.

#### **5.14 Мэдээлэл түгээх туршилтын хөтөлбөрийн хэрэгжилт (Сум 4)**

Энэхүү үйл ажиллагаа нь дээрх 5.8 дугаар хэсэгт дурдагдсан Сум 1 дээр хэрэгжүүлэхтэй ижил үйл явцын дагуу хийгдэнэ.

#### **5.15 Мэдээлэл харилцааны үйл ажиллагааны хэрэгжилтийн төлөвлөгөө (Сум 5)**

Энэхүү үйл ажиллагаа нь дээрх 5.7 дугаар хэсэгт дурдагдсан Сум 1 дээр хэрэгжүүлэхтэй ижил үйл явцын дагуу хийгдэнэ.

#### **5.16 Мэдээлэл түгээх туршилтын хөтөлбөрийн хэрэгжилт (Сум 5)**

Энэхүү үйл ажиллагаа нь дээрх 5.8 дугаар хэсэгт дурдагдсан Сум 1 дээр хэрэгжүүлэхтэй ижил үйл явцын дагуу хийгдэнэ.

#### **5.17 Түгээн дэлгэрүүлэх шинэчлэгдсэн төлөвлөгөө**

Туршилтын хүрээнд хамрагдах бүх сумд дээр мэдээлэл түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлсэний дараагаар бидний зүгээс **Түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөөнд** нэмэлт оруулан шинэчлэн гаргана. Энэхүү төлөвлөгөөнд туршилтын журмаар 5 сумдад хийгдэх мэдээлэл түгээх үйл ажиллагааны хэрэгжилтийн сургамжууд болон мэдлэгийг тусгана. Тус төлөвлөгөө нь хөтөлбөрийн үндэсний хэмжээнд (заавал бүх сумдад хүрэх шаардлагагүй) түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг, хамаарах төсвийн хамтаар тусгах юм. Мөн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн 5 сумаас гадна тэргүүлэх ач холбогдол бүхий бусад сумдыг мөн санал болгоно.

#### **5.18 Эцсийн тайлан**

Хөтөлбөрийн **Эцсийн тайлан** нь тус хөтөлбөрийн хүрээнд гарах сүүлийн бүтээгдэхүүн байх ба 2017 оны 12 дугаар сард ЕСБХБ болон АСИ-ийн хооронд байгуулсан гэрээний хугацаа дуусахаас өмнө бэлтгэгдэн гарна. Хөтөлбөрийн үндсэн үр дүнгүүдийг танилцуулах, хэлэлцэх зорилго бүхий **ОТОАХ-ийн хурал** тайлан гарсны дараа зохион байгуулагдана.



8 Турштын хөлөгбөрийг бусад сумдад өргөжүүлэх				
8.1	Өргөжүүлэх/туслах төлөвлөгөө болон хэрэгжүүлэх төлөвлөгөө байдал	PC.MCC		
8.2	Төлөвлөгөө ЕСБХБ-нд хүргүүлэх	PC.MCC	15	
8.3	ЕСБХБ тайвнийн татаарх самалаа өгөх	OL		
8.4	Өргөжүүлэх/туслах төлөвлөгөө, хэрэгжүүлэх төлөвлөгөөг эцэслэн, Монгол хэлэнд орчуулах	PC.MCC,TR		
8.5	Туслах төлөвлөгөө, хэрэгжүүлэх төлөвлөгөөг Монгол, Англи хэл дээр эцэслэн гаргах	PM	16	
9 Мэдээлэл харилцааны хэрэгжилтийн төлөвлөгөө (Сум 2)				
9.1	Мэдээлэл харилцааны хэрэгжилтийн төлөвлөгөө байдал	PC.MCC		
9.2	Мэдээлэл харилцааны хэрэгжилтийн төлөвлөгөөг ЕСБХБ-нд хүргүүлэх	PM	17	
9.3	ЕСБХБ тайвнийн татаарх самалаа өгөх	OL		
9.4	Хэрэгжилтийн төлөвлөгөөг эцэслэн, Монгол хэлэнд орчуулах	PC.MCC,TR		
9.5	Хэрэгжилтийн төлөвлөгөөг Монгол, Англи хэл дээр эцэслэн гаргах	PM	18	
10 Мэдээлэл түгээх турштын хөлөгбөрийг хэрэгжүүлэх (Сум 2)				
10.1	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлэх, арга хэмжээ зохиох	PC.MCC		
10.2	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвнийн төсөл байдал	PC.MCC		
10.3	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвнийн төслийг ЕСБХБ-нд хүргүүлэх	PM	19	
10.4	ЕСБХБ тайвнийн татаарх самалаа өгөх	OL		
10.5	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвняг эцэслэн, Монгол хэлэнд орчуулах	PC.MCC,TR		
10.6	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвняг Монгол, Англи хэл дээр эцэслэн гаргах	PM	20	
11 Мэдээлэл харилцааны хэрэгжилтийн төлөвлөгөө (Сум 3)				
11.1	Мэдээлэл харилцааны хэрэгжилтийн төлөвлөгөө байдал	PC.MCC		
11.2	Мэдээлэл харилцааны хэрэгжилтийн төлөвлөгөөг ЕСБХБ-нд хүргүүлэх	PM	21	
11.3	ЕСБХБ тайвнийн татаарх самалаа өгөх	OL		
11.4	Хэрэгжилтийн төлөвлөгөөг эцэслэн, Монгол хэлэнд орчуулах	PC.MCC,TR		
11.5	Хэрэгжилтийн төлөвлөгөөг Монгол, Англи хэл дээр эцэслэн гаргах	PM	22	
12 Мэдээлэл түгээх турштын хөлөгбөрийг хэрэгжүүлэх (Сум 3)				
12.1	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлэх, арга хэмжээ зохиох	PC.MCC		
12.2	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвнийн төсөл байдал	PC.MCC		
12.3	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвнийн төслийг ЕСБХБ-нд хүргүүлэх	PM	23	
12.4	ЕСБХБ тайвнийн татаарх самалаа өгөх	OL		
12.5	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвняг эцэслэн, Монгол хэлэнд орчуулах	PC.MCC,TR		
12.6	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвняг Монгол, Англи хэл дээр эцэслэн гаргах	PM	24	
13 Мэдээлэл харилцааны хэрэгжилтийн төлөвлөгөө (Сум 4)				
13.1	Мэдээлэл харилцааны хэрэгжилтийн төлөвлөгөө байдал	PC.MCC		
13.2	Мэдээлэл харилцааны хэрэгжилтийн төлөвлөгөөг ЕСБХБ-нд хүргүүлэх	PM	25	
13.3	ЕСБХБ тайвнийн татаарх самалаа өгөх	OL		
13.4	Хэрэгжилтийн төлөвлөгөөг эцэслэн, Монгол хэлэнд орчуулах	PC.MCC,TR		
13.5	Хэрэгжилтийн төлөвлөгөөг Монгол, Англи хэл дээр эцэслэн гаргах	PM	26	
14 Мэдээлэл түгээх турштын хөлөгбөрийг хэрэгжүүлэх (Сум 4)				
14.1	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлэх, арга хэмжээ зохиох	PC.MCC		
14.2	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвнийн төсөл байдал	PC.MCC		
14.3	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвнийн төслийг ЕСБХБ-нд хүргүүлэх	PM	27	
14.4	ЕСБХБ тайвнийн татаарх самалаа өгөх	OL		
14.5	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвняг эцэслэн, Монгол хэлэнд орчуулах	PC.MCC,TR		
14.6	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвняг Монгол, Англи хэл дээр эцэслэн гаргах	PM	28	
15 Мэдээлэл харилцааны хэрэгжилтийн төлөвлөгөө (Сум 5)				
15.1	Мэдээлэл харилцааны хэрэгжилтийн төлөвлөгөө байдал	PC.MCC		
15.2	Мэдээлэл харилцааны хэрэгжилтийн төлөвлөгөөг ЕСБХБ-нд хүргүүлэх	PM	29	
15.3	ЕСБХБ тайвнийн татаарх самалаа өгөх	OL		
15.4	Хэрэгжилтийн төлөвлөгөөг эцэслэн, Монгол хэлэнд орчуулах	PC.MCC,TR		
15.5	Хэрэгжилтийн төлөвлөгөөг Монгол, Англи хэл дээр эцэслэн гаргах	PM	30	
16 Мэдээлэл түгээх турштын хөлөгбөрийг хэрэгжүүлэх (Сум 5)				
16.1	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлэх, арга хэмжээ зохиох	PC.MCC		
16.2	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвнийн төсөл байдал	PC.MCC		
16.3	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвнийн төслийг ЕСБХБ-нд хүргүүлэх	PM	31	
16.4	ЕСБХБ тайвнийн татаарх самалаа өгөх	OL		
16.5	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвняг эцэслэн, Монгол хэлэнд орчуулах	PC.MCC,TR		
16.6	Турштын хөлөгбөрийг хэрэгжүүлсэн тайвняг Монгол, Англи хэл дээр эцэслэн гаргах	PM	32	
17 Турштын төслийн түгээн дэлгэрүүлэх тайвняг шинэчлэн байдал				
17.1	Тайвняг эргэн үзэх, өөрчлөлт оруулах, Монгол хэлэнд орчуулах	PC,TR		
17.2	Шинэчилсэн тайвняг ЕСБХБ-нд хүргүүлэх	PM	33	
18 Эцсийн тайлан				
18.1	Төслийн эцсийн тайвнийн төсөл байдал	PC,PM		
18.2	Төслийн эцсийн тайвняг ЕСБХБ-нд хүргүүлэх	PM	34	
18.3	ЕСБХБ тайвнийн татаарх самалаа өгөх	OL		
18.4	Төслийн эцсийн тайвняг эцэслэн, Монгол хэлэнд орчуулах	PC,PM,TR		
18.5	Төслийн тайвняг Монгол, Англи хэл дээр эцэслэн гаргах	PM	35	

## 6. Боловсон хүчин

Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд ОУИТБС-ын Ажлын албанд дэмжлэг үзүүлэх баг нь нийт зургаан гишүүн болон түншлэгч компанийн төлөөллөөс бүрдэнэ. Үүнд:

- Үйл ажиллагаа хариуцсан ахлагч – Пол Моффат, ЕСБХБ
- Багийн ахлагч – Жонатан Пелл, АСИ
- Хөтөлбөрийн зохицуулагч – Н.Золжаргал
- Хөтөлбөрийн менежер – Антонья Михайлова, АСИ
- Мэдээлэл харилцааны олон улсын зөвлөх 1 – Сефтон Дерби, Хэрэгцээний үнэлгээ болон ОУИТБС-ын Мэдээлэл харилцааны стратеги, орон нутаг дахь үйл ажиллагааг судлан үнэлэх
- Мэдээлэл харилцааны олон улсын зөвлөх 2 – Жулиа Бакстер, АСИ, Мэдээлэл харилцааны стратеги боловсруулах
- Мэдээллийн туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий, мэдээлэл харилцааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын аж ахуйн нэгж

Хөтөлбөрийн хэрэгжилтэд тулгарах хэрэгцээнд үндэслэн бид мөн нэмэлт нөөц, эх үүсвэрийг ашиглаж болох ба ялангуяа сумдад хийгдэх мэдээлэл түгээх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллах сумдын түвшин дэхь хувь хүмүүс, байгууллагуудыг нэмэлтээр ажиллуулах боломжтой юм.

## 7. Олон талт оролцогчдын ажлын хэсгийн үүрэг роль

ОТООХ-ийн гишүүдийн мэдлэг, Монгол Улсын хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байсан тэдний туршлага нь хөтөлбөрийн үндсэн чиглэлийг тодорхойлоход тус дэм үзүүлнэ гэдэгт бидний зүгээс найдаж байна. Дээрх шалтгааны улмаас доор дурдсан тайлангуудыг бэлтгэн гаргасны дараагаар нийт 4 удаагийн ОТООХ-ийн хуралдаан зохион байгуулагдана хэмээн бидний зүгээс тооцож байна:

- Сум сонголтын тайлан;
- Орон нутгийн мэдээлэл харилцааны стратегийн ерөнхий тайлан;
- Мэдээлэл түгээх туршилтын хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан; болон
- Эцсийн тайлан.

Дээр дурдсанчлан сумдын хэрэгцээний үнэлгээг хийх хугацаанд иргэний нийгмийн байгууллагуудтай нягт уялдаатай ажиллаж, тэдний саналыг судлан, сум бүхэнд зайлшгүй шаардлагатай чухал, онцлог асуудлуудын талаар тухайн байгууллагуудын гаргах зөвлөмжүүдийг мөн харгалзан үзэх юм. Бидний зүгээс ажлын хэсгийг төлөөлөн Засгийн газар, компани болон иргэний нийгмийн нэг нэг гишүүнийг 3 дугаар сард хийж гүйцэтгэх сумдын ерөнхий хүрээг тодорхойлох аялалд (нийт гурван хүн) урьж оролцуулах санал болгож байна..

